



ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Шихихутуг Их Сургууль

Хөтөлбөрийн нэр: “Эрх зүй” бакалаврын хөтөлбөр

Индекс: 042101

Шинжээчийн баг:

Ахлагч: А.Оюунчимэг

Гишүүд: Д.Эрдэнэбаатар

Н.Эрдэнэхүү

Улаанбаатар хот

2019-05-20

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

- PESTLE- Political, Economic, Social, Technological, Legal and Environmental analysis
- PEOs-Program Educational Objectives
- PLOs-Program Learning Outcomes
- CLOs-Course Learning Outcomes
-

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Шихихутуг их сургууль Shikhikhutug University	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	“Эрх зүй”	
Индекс	D042101	
Шинжээчид	Шинжээчийн багийн ахлагч: А.Оюунчимэг - Өмгөөллийн ОМН Партнершип ХХК-ий захирал Шинжээчийн багийн гишүүн: Д.Эрдэнэбаатар - Дотоод хэргийн их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал Шинжээчийн багийн гишүүн: Н.Эрдэнэхүү - ШУТИС-ийн Мэдээлэл, холбоо технологийн сургуулийн дэд захирал	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	П.Оргилмаа	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2019.05.06	Мэргэжилтэн шинжээчдийн нэрсийг хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багт илгээж, ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар саналыг хүлээн авах
	2019.05.07	Шинжээчийн багийг томилох
	2019.05.08	Шинжээчидтэй гэрээ байгуулах
	2019.05.08	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгнө.
	2019.05.13	Шинжээчид тодруулах асуудлын жагсаалт гаргаж өгнө
	2019.05.14	Сургууль дээр ажиллах: Удирдлага болон өөрийн үнэлгээний багтай уулзах, Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой танилцах, Сургуультай танилцах, Оюутнуудтай уулзалт хийх, Багш нартай уулзах Номын сан, лаборатори, үйлчилгээний хэсэгтэй танилцах
	2019.05.15	Сургууль дээр ажиллах: Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах, Ажил олгогчидтой уулзах, Төгсөгчидтэй уулзах, Шинжээчдийн багийн уулзалт хийх, Урьдчилсан дүгнэлтийг байгууллагад танилцуулах

	2019.05.22	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2019.05.22	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	2019:05.24	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
	Хуваарьт хуралдаан	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.
Шалгуур шаардлага /журам/		<ul style="list-style-type: none"> • БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан “Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”, • “Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлага”, Боловсролын сайдын А/174 тоот тушаалаар батлагдсан хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага, • Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 26 тоот тушаалаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам” • Бусад холбогдох дүрэм, журмууд

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Шихихутуг их сургууль нь 1991 оноос “Эрх зүй” бакалаврын түвшний сургалтын хөтөлбөрийг тасралтгүй 28 жилийн турш хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайн хөтөлбөр нь “Бизнесийн эрх зүй” нарийвчилсан чиглэлтэй, өдрийн сургалтын зэрэгцээ эчнээ хэлбэрийн сургалттай.

Бакалаврын түвшний “Эрх зүй” хөтөлбөрт шат дараалсан шинэчлэлт, өөрчлөлтүүд хийж ирсэн байна. Тухайлбал,

2003-2013 онуудад агуулгын шинэчлэл, 2014-2018 онуудад дээд боловсролын шинэчлэл, сургуулийн стратеги бодлоготой уялдуулсан сайжруулалт, 2018-2019 оны хичээлийн жилээс сургуулийн эрхэм зорилгын хүрээнд хөтөлбөрийн стандартыг шинэчилж эхэлсэн.

Сургалт, судалгааны үйл ажиллагаандаа өөрийн үнэлгээ хийж, байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд тухай бүр хамрагдан чанараа баталгаажуулж иржээ. Тухайлбал,

2001 онд дээд боловсролын байгууллагын анхан шатны, 2006 онд ахисан түвшний, 2018 онд 3 дахь шатны, 2011, 2014 онуудад “Эрх зүй”, “Бизнесийн эрх зүй” сургалтын хөтөлбөрүүдийг тус тус магадлан итгэмжлүүлсэн байна.

Шихихутуг их сургууль 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн “Эрх зүй” бакалаврын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, үр дүнд суурилсан боловсролын арга зүйг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Үр дүнд суурилсан сургалтын технологийн дагуу “Оюутан төвтэй” үнэлгээний арга зүйг нэвтрүүлж эхэлсэн.

“Эрх зүй” хөтөлбөр нь Эрдмийн зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хурлаар хэлэлцэн дэмжигдэж, 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар нэмэлт өөрчлөлт оруулахыг дэмжсэн байна.

“Эрх зүй” Бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн 3 хэсгээс бүрдэх бөгөөд нэгдүгээр хэсэгт Хөтөлбөрийн танилцуулга, Хойрдугаар хэсэгт Хөтөлбөрийн үндэслэл-төгсөгчийн загвар, гуравдугаар хэсэгт Хөтөлбөрийн зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүнгүүд, сургалтын нэгдсэн төлөвлөгөө, сургалтын төлөвлөгөөнийн хичээл-суралцахуйн үр дүнгүүд хоорондох матриц, хичээлийн хөтөлбөрийн загвар, сургах, заах арга зүй, хүргэх хэлбэрүүд, хөтөлбөрийн үнэлгээ сайжруулалт, суралцах орчин, элсэгчид тавих шаардлага, багид тавигдах шаардлага, хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт ба удирдлагын мэдээллийн систем, харилцаа хамтын ажиллагаа зэргийг тусгаж өгсөн байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн эрэлт, хэрэгцээг тодорхойлох PESTLE шинжилгээний үр дүн
- Дотоод, гадаадын ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа
- Ажил олгогчид, төгсөгчид, төгсөгчдийн Чандмань холбоо зэрэг оролцогч талуудын саналыг хөтөлбөрийн төлөвлөлтөд тусгасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг тодорхойлохдоо олон улсад өргөн ашиглагдаж байгаа үр дүнд суурилсан боловсролын арга зүйг үндэс болгож, эрх зүйн хөтөлбөрөөр төгсөгчдийн загварыг 6 үзүүлэлтээр гаргасан байна. Энэ нь Шихихутуг их сургуулийн төгсөгчдийн бусад сургуулийн төгсөгчдөөс ялгарах онцлогийг харуулж чаджээ.

Анхаарах асуудал:

- Бакалаврын сургалтын 3 төлөвлөгөө хэрэгжүүлж байгаа тул шинжилгээг сургалтын төлөвлөгөө тус бүрт хийвэл хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ шаардлагыг илүү бодитой тодорхойлно.
- Эрх зүйн хөтөлбөрийн олон улсын чиг хандлагыг тодорхойлж, хөтөлбөрт тусгах талд цаашид анхаарч ажиллах.

Зөвлөмж:

- Шинжилгээний S хэсгийн дүгнэлтийг тодруулж, тодорхой шийдэл санал болгох.

- Эрх зүйн чиглэлийн сургалтын хөтөлбөрөөр төгсөгчдийн ажлын байрны судалгаа, эрэлт хэрэгцээ, олон улсын чиг хандлага, зэрэг олон хүчин зүйлүүдийг харгалзан төгсөгчийн загварыг баталгаажуулах

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн боловсролын зорилтууд(PEOs)-ыг 4 үзүүлэлтээр, хөтөлбөрийн суралцахуйн үр дүн буюу төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлагын жагсаалт(PLOs)-ыг 9 үзүүлэлтээр тус тус тодорхойлж их сургуулийн эрхэм зорилго, үндэсний мэргэшлийн хүрээний төсөлтэй хэрхэн уялдаж байгааг тодорхойлсон. Оюутны гарны авлага, хөтөлбөрийн вэб сайт зэргийг ашиглан энэ мэдээллийг нийтэд түгээсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Үр дүнд суурилсан боловсролын арга зүйн дагуу хөтөлбөрийн PEOs, PLOs-ийг тодорхойлсон. Энэ нь оролцогч талууд болох багш нар, ажил олгогчид, төгсөгчдийн хүрээнд хэлэлцэгдэн баталгаажсан байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн боловсролын зорилтууд болон суралцахуйн үр дүнг сайн тодорхойлсон хэдий ч төгсөгчийн загвар 6 үзүүлэлттэй сайн уялдуулаагүй байна.
- Англи хэлний сургалтыг шинэ шатанд гаргаж тус их сургуулийн төгсөгчийн нэг ялгарах шинж болгоно гэж үзэж Оксфордын хөтөлбөр нэвтрүүлсэн хэдий ч хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй холбоогүй байна.

Зөвлөмж:

- Төгсөгчийн загвар, PEOs, PLOs хоорондын уялдааг нарийн гаргах
- Гадаад, дотоодын ижил төстэй хөтөлбөртэй харьцуулах, бэнчмаркинг хийх талд цаашид анхаарч ажиллах

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Боловсролын сайдын A/174 тоот тушаалаар батлагдсан хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагад нийцүүлэн сургалтын хөтөлбөр боловсруулж, хэлэлцэн баталсан байна.

- Сургалтын хөтөлбөрт тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын жагсаалт, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний хэлбэрүүдийг нэг бүрчлэн төлөвлөж оруулсан байна.
- Мөн сургалтын хөтөлбөрийг оролцогч талуудаар хэлэлцүүлж баталгаажуулсан нотолгоонууд байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Боловсролын сайдын А/174 тоот тушаалаар батлагдсан хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага, мөн үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрт тавигдах стандарт шаардлагуудад бүрэн нийцүүлж боловсруулсан нь энэ чиглэлийн бусад хөтөлбөрүүдэд авууштай сайн туршлага болохоор байна.
- Хичээл хоорондын залгамж уялдааг Flowchart хийх замаар гаргасан нь сайн туршлага болно гэж үзсэн.

Анхаарах асуудал:

- Энэ шинэ хөтөлбөр нь өмнө хэрэгжүүлж ирсэн сургалтын хөтөлбөрөөс юугаараа ялгаатай болох, ямар ямар дутагдалтай талуудыг шинэчилэн сайжруулсан талаар харьцуулсан судалгаа бага байна.
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/174 дүгээр тушаалаар баталсан хэм хэмжээнд нийцүүлэн сургалтын төлөвлөгөөг боловсруулсан эсэх талаар Өөрийн үнэлгээний тайланд тусгаагүй.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн бичиг баримтууд стандарт шаардлагад нийцэж байгаа хэдий ч чанарын баталгаажуулалт зэрэг зарим бүлгийг илүү сайн боловсруулах нь зүйтэй гэж зөвлөж байна.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хөтөлбөрийн 9 суралцахуйн үр дүнтэй уялдаатайгаар хичээлүүдийн агуулга, хичээл хоорондын уялдааг нарийн тодорхойлж хөтөлбөр төлөвлөлтийн бичиг баримтад бүрэн тусгасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн 9 суралцахуйн үр дүнг оюутанд эзэмшүүлэхэд сургалтын хөтөлбөрт байгаа хичээл бүр ямар үүрэгтэй болохыг матриц байдлаар нарийн гаргасан байна.
- Үйлдвэрлэлийн дадлага, клиник сургалтаар оюутанд практик ур чадвар олгох боломжийг бүрдүүлсэн.
- Хичээлийн хөтөлбөрт хичээлээр олгох, мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлж хичээлийн агуулгатай уялдуулсан нь онцлогтой байна.

Анхаарах асуудал:

- Сонгон хичээлүүд байдаг хэдий ч оюутан сонгох боломж муутай. Өөрөө хэлбэл анги дүүргэлтээс хамаарч зарим хичээлийг шууд судлуулдаг.

Зөвлөмж:

- Оюутан өөрийн сонирхсон хичээлийг судлах боломж бүрдүүлэх
- Хичээлийн нэг улиралд судлах хичээлийн тоо хэт их, ихэнх хичээлийн багц цагийг 3-аас доошгүй байхаар тогтоох нь зүйтэй гэж үзэв.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагч төвтэй сургалтын арга зүйг 5 багцаар тодорхойлж сургалтын хөтөлбөрийн бичиг баримтад тусгасан байна.
- Сургалтын төлөвлөгөөнд байгаа хичээл бүрээр сургалтын арга зүйг нарийн төлөвлөж хичээлийн дэлгэрэнгүй хөтөлбөр боловсруулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Лекц, семинар, дадлага, клиник сургалт зэрэг уламжлалт хүргэх хэлбэрүүдийн хувьд орчин үеийн сургалтын арга зүйг хэрхэн ашиглах талаар хичээлийн хөтөлбөрийн хүрээнд нарийн төлөвлөлт хийсэн нь бусад хөтөлбөрүүдэд сайн туршлага болохоор болсон байна.

Анхаарах асуудал:

- Хэдийгээр сургалтын арга зүйг шинэ хэлбэрээр төлөвлөсөн боловч сургалтанд хэрхэн нэвтрүүлж, ямар үр дүнд хүрсэн талаар нотлох баримт дутмаг байна.
- Мэдээлэл холбооны технологийн ололтыг сургалтанд ашиглах /PPT, прожектор ашиглах хэлбэрээр хязгаарлахгүй байх/ талд анхаарах

Зөвлөмж:

- Сургалтын шинэ аргуудыг олон хичээлд хэрэгжүүлэх, үр дүнг уламжлалт аргуудтай харьцуулах, нээлттэй хичээлүүдийг шинэ арга зүйгээр зохион байгуулж багш нар харилцан туршлагаа солилцох, түгээн дэлгэрүүлэх боломжийг бүрдүүлэх
- Мэдээлэл холбооны технологийн холимог сургалт, тонгоруу сургалт, онлайн шалгалтууд гэх мэт олон хэлбэрийг ашиглах чиглэлээр төлөвлөгөө гарган ажиллах

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн хөтөлбөрөөс гадна суралцагчийн эзэмшсэн мэдлэг, ур чадвар, хандлага төлөвшлийг үнэлэх төлөвлөгөөг хичээл бүрээр боловсруулсан байна.
- Энэ төлөвлөгөөний хүрээнд хичээлийн суралцахуйн үр дүнг шууд бус үнэлгээгээр хэрхэн үнэлэх тогтсон арга зүйг бий болгожээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хичээлийн суралцахуйн үр дүнг хэрхэн үнэлэх төлөвлөлт хийх, рубрикэн үнэлгээг хэрхэн ашиглах талаар нарийн төлөвлөлт хийсэн нь бусдад туршлага болохоор болжээ.

Анхаарах асуудал:

- Хэдийгээр хичээлийн явцын болон эцсийн үнэлгээг суралцахуйн үр дүнтэй холбон үнэлэх төлөвлөлт хийсэн боловч хэрэгжүүлсэн үр дүн бараг байхгүй байна.
- Хичээлийн шууд үнэлгээг суралцахуйн үр дүн талаас нь үнэлэх ажил хийгдээгүй байна.

Зөвлөмж:

- Хичээл бүрийн суралцахуйн үр дүнгүүдийг үнэлэх төлөвлөгөөг дараагийн хичээлийн жилээс хэрэгжүүлж, сайжруулах шаардлагатай
- Мөн хичээлийн шалгалтын материалуудыг суралцахуйн үр дүнтэй уялдуулж боловсруулах талд анхаарч ажиллах

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

Илрэл нотолгоо:

- “Шихихутуг” Хуульзүйн Дээд Сургуулийн өмчлөх эрхийн гэрчилгээ дугаар 000193257 / 1300 ам метр талбайтай таван давхар/
- “Шихихутуг их сургууль” боловсрол сургалтын байгууллага эд хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ дугаар 000681726 / 538,36 мкв талбайтай, сургалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө/
- Газар эзэмших гэрчилгээ дугаар 000002126,0172936,000304906.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

Дээд боловсролын байгууллагад тавигдах стандартын дагуу сургалт, судалгааны дараах орчныг бүрдүүлээд байна. Үүнд:

- Тус сургууль нь орчиндоо 250 кв.м талбайтай, оюутнуудын аюулгүй байдлыг хангах үүднээс өмнөх машин замаас тусгаарлагдсан хашаа, бетондсон талбайтай.
- Сургуулийн барилга хийц материалын хувьд стандартад нийцсэн эрүүл, аюулгүй, анги танхимийн зохион байгуулалт сайтай, агаар сэлгэлт, байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг сайтай.
- Харуул хамгаалалтын хувьд тогтмол ажилладаг 3 ээлжийн жижүүртэй. Бүх давхруудад болон лекцийн заал, номын сан, оффисын өрөөнүүдэд өндөр хүчин чадалтай хяналтын камер суурилуулсан.
- 30 хүний суудалтай цайны газар 12 цагаар багш, ажилтан, оюутнуудад үйлчилдэг, хоолны үнэ харьцангуй хямд, хүнсний зүйл бэлтгэх, хадгалах шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан.
- Давхар бүрт ариун цэврийн өрөө байрладаг ба өрөө бүр эрэгтэй эмэгтэйгээр тусгаарлагдсан, угаалтуурууд хангалттай устай.
- Бохирын систем, хогийн сав, хогийн цэгийн асуудал бүрэн шийдэгдсэн.
- Сургалтын анги танхим бүрт сүүлийн үеийн хүчин чадал бүхий проектор, дэлгэц, ухаалаг индэр, ухаалаг самбарыг иж бүрнээр нь суурилуулахаас гадна зөөврийн notebook, чанга яригч / station/, зөөврийн самбар, зэргийг сургалтандаа ашигладаг.
- Дотоод сүлжээ, интернетэд холбогдсон Core i3 CPU 3.3GHz, 4GB DDR 500GB HDD үзүүлэлт бүхий сүүлийн үеийн хурд багтаамж сайтай компьютер, принтерээр багш ажилтан, тэнхим, нэгж бүр бүрэн хангагдсан. /Мини хэвлэлийн машин, цех/
- Номын санг орчин үеийн нөхцөл шаардлагад нийцсэн үйл ажиллагаатай болгон, сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоногдсон.
- Сургуулийн бүхий л орчин шилэн кабелиар холбогдсон wifi буюу утасгүй 24 цагийн интернетэд холбогдсон, интернет ашиглах боломж нээлттэй.

- Оюутан бүр Жи-мобайл нэт компаний шилэн кабелийг 5mb dedicated хурдтайгаар, Юнител компаний оюутанд зориулсан үйлчилгээ болох OYUTANWIFI-г 2mb хурдтайгаар тус тус сургуулийн хэмжээнд үнэ төлбөргүй ашиглах боломжтой.

Шихихутуг Их сургууль нь 2005 онд ашиглалтанд орж, 2014 онд өргөтгөл хийгдсэн 1578.5 м² талбай бүхий хичээлийн байрандаа 2 ээлжээр хичээллэж, 1 ээлжиндээ 480 оюутан хичээллэх хүчин чадалтайгаар ашиглаж байна. Хичээлийн байрны хүчин чадлыг нэмэгдүүлэх үүднээс 3675 м/кв талбай бүхий шинэ байрыг 2019 оны 8-р сард ашиглалтанд оруулахаар, мөн түүнчлэн сургалт, судалгааны бааз бий болгох зорилгоор шинэ баригдаж байгаа байртайгаа залгаа 538,36 м/кв талбай бүхий объектыг худалдан авч засвар үйлчилгээ хийж, 2019-2020 оны хичээлийн жилээс ашиглаж эхлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Ингэснээр орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, зай талбай ихтэй, гэрэлтүүлэг, агааржуулалт сайн, дуу чимээ тусгаарлагдсан анги танхим, лабораториуд, технологийн шийдэл сайтай хурлын танхим, биеийн тамирын заал, номын сан, архив өрөө, манайд одоогоор дутагдаад байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн зорчих зам, тэдний суралцах нөхцөл, ариун цэврийн өрөө, зэрэг олон асуудал шийдэгдэнэ.

Анхаарах асуудал:

Бие дааж болон багаар суралцах сургалтын орчинг бүрдүүлэх.

Зөвлөмж:

- Сургалтын цахим орчинд ажиллах орчин бүрдүүлэх жишээ нь албан бичгийн хөтлөлт, эрх зүйн үйлчилгээний орчинд ажиллах программ хангамжийг нэмэгдүүлэх.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Шихихутуг Их Сургуулийн Хөтөлбөрийн хорооны журам Шихихутуг их сургуулийн захирлын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн а/87 тоот тушаалын хавсралт.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын нэгж хичээлийн хэрэглэгдэхүүн болох бичгийн цаас, шохой, маркер, самбарын цаас, заагч үзэг, чанга яригч, флаш, принтерийн хор зэргийг улирал, улирлаар нөөцлөн ашиглахаас гадна Шихи-хүү цуврал хичээл, “Хууль ба амьдрал” сургалтын видео хичээлүүдийг ашиглаж байна.
- Хууль болон хуулийн эмхтгэлүүд, бодлогын судалгааны эмхтгэлүүд, гарын авлага, төрөл бүрийн гэрээний загвар, маягт зэргийг сурах бичгээр ашиглуулахаас гадна сүүлийн үеийн чиг хандлагын дагуу цахимаар хэрэглэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

- Бакалавр, магистрын судалгааны ажил, мэргэжлийн дадлагын тайлангийн санг хэвлэмэл болон цахимаар бий болгон ашиглаж байна.
- Сургууль нь сургалтандаа их, дээд сургуулийн бүхий л үйл ажиллагааг хамарсан цогц систем болох *Cloud university*, номын сангийн цогц программ *Lib4u*, нягтлан бодох бүртгэлийн *Венница* зэрэг тусгай зориулалтын программ хангамжуудыг лиценцтэйгээр ашигладаг.
- Багш нар сургалтандаа өргөн хэрэглээний программ болох MS-Office багц программ, цахим хичээл бэлтгэх *iSpring suite*, *Adobe Flash*, *судалгааны SPSS* зэрэг программуудыг ашиглаж байна.
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийг хөтөлбөрт оролцогчдод Шихихутуг их сургуулийн вэб хуудас, их дээд сургуулиудын боловсролын үзэсгэлэн, нээлттэй өдөрлөг, олон нийтийн хэвлэл мэдээлэлийн хэрэгсэл, мэргэжил сурталчлах хичээлээр болон сургалтын үйл ажиллагааны явцад холбогдох нэгжийн мэдээллийн самбар, анги бүлгийн зохион байгуулалтын бүтцээр, хэвлэмэл материал буюу Багшийн гарын авлага, Оюутны гарын авлага зэргээр түгээж байна.

Анхаарах асуудал:

Зөвлөмж:

-

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага /MNS5742:2007/стандартад нийцсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Эрх зүйн шинжлэх ухааны төрөлжсөн ном болон мэдээллийн санг бий болгох, үйлчилгээний чанар, соёл, хүртээмжийг сайжруулах, цахим номын сан байгуулах зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- 48 суудалтай чөлөөт сонголттой уншлагын танхим, 10 суудалтай эрдэм шинжилгээ, судалгааны уншлагын танхим, 22 суудал бүхий Е-уншлагын танхимаар үйлчилдэг.
- Сургуулийн номын сан нь Монгол Улсын Стандартчилал, хэмжил зүйн /MNS5742:2007/ стандартын шаардлагыг ханган ажилладаг.
- Нийт 20 мянга гаруй ном, сурах бичиг, гарын авлага, сэтгүүлийн сан хөмрөгтөй, нэг суралцагчид мэргэжлийн 21-22 ном, гарын авлага оногдож байна.

- Хичээлийн шинэчилсэн хөтөлбөрийн зорилго, зорилтыг /PEOs/ хангах, оюутнуудын суралцахуйн үр дүнг /PLOs/ сайжруулах, тэдний мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх зорилгоор номын фондыг мэргэжлийн ном, сурах бичиг, сэтгүүл, гарын авлага, судалгааны материалаар баяжуулахаас гадна номын ашиглалт, хэрэглээ тал дээр ихээхэн анхаарч ажиллаж байна.
- Ном сурах бичгийн өсөлт жилд дундажаар 4% байна. Өмнөх хичээлийн жилүүдэд номын фондын баяжилтанд сургуулийн нийт төсвийн 0.3 орчим хувийг төсөвлөдөг байсан бол энэ хичээлийн жилээс номын фонд, цахим сан хөмрөгийн баяжилтыг нэмэгдүүлэх зорилгоор төсвийн 3 орчим хувийг зарцуулахаар төлөвлөн ажиллаж байна.
- 2015-2016 оны хичээлийн жилээс цахим номын сан байгуулж, сан хөмрөгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд, цахим санг одоогийн байдлаар 150 гаруй магистрын ажил, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 30 орчим сэтгүүл, бусад ном сурах бичиг, судалгааны ажлаар баяжуулаад байна.
- Уламжлалт буюу номын сангийн ажилтнаар дамжуулан хэрэгцээт ном, сэтгүүлээ захиалан авдаг байсныг өөрчилж суралцагч нь номын фондод өөрийн биеэр орж хэрэгцээт мэдээллээ авах боломжтой болсон.
- 2017-2018 оны хичээлийн жилээс номын сангийн програмыг LIB4U.CLOUD болгон үйлчилгээндээ нэвтрүүлснээр суралцагчдад интернет сүлжээтэй хаанаас ч хандан электрон каталогиос номын нэрээр хайлт хийх, өөрийн нэвтрэх нэр, нууц үгийг ашиглан цахим хэвлэлийг унших, мөн өөрийн нэр дээр бүртгэлтэй байгаа хэвлэлийн буцаах хугацааг харах зэрэг олон үйлчилгээг авах боломж бүрдсэн.
- Программ нь цахим фондод бүртгэгдсэн бүтээлийг хувилан олшруулах, хэвлэн авах боломжгүй нууцлалын өндөр хамгаалалттай ба вэб хэрэглээний хандалтыг хянадагаараа онцлог.
- Жил бүрийн 04 сарын 23 буюу дэлхийн номын өдрөөр “Номтой Шихихутугчууд” өдөрлөгийг тогтмол зохион байгуулж хэвшсэн. Өдөрлөгөөр Шилдэг уншигч-аа тодруулах, өөр хоорондоо хэрэгцээт номоо солилцох, тухайн хичээлийн жилд фондод шинээр нэмэгдсэн ном хэвлэлийг танилцуулах, Зохиогч уншигчийн уулзалт зэрэг үйл ажиллагааг зохион байгуулдаг.
- Номын сан нь соронзон мэдрэгчтэй хаалга, 3 үйлдэлт принтер, хэвлэмэл эхийг цахим болгох “Scan snap ix500” төхөөрөмж, ном сэлбэн засах (үдэх, наах, зүсэх, өрөмдөж цоолох) иж бүрэн төхөөрөмжтэй.

Анхаарах асуудал:

-

Зөвлөмж:

- Мэргэжлийн ном, сэтгүүл, судалгааний сангийн эрэлт хэрэгцээг оновчтой зөв тодорхойлж баяжилт хийх, судалгаа хийх арга зүйг боловсронгуй болгох.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Шихихутуг Их сургуулийн хөтөлбөрийн хорооны журам 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн а/87 тоот захирлын тушаал.
- Шихихутуг Их сургуулийн хөтөлбөр хөгжүүлэх стратеги төлөвлөгөө
- Шихихутуг Их сургуулийн эрдмийн зөвлөлийн дүрэм
- Шихихутуг Их сургуулийн тэнхимийн дүрэм

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн хороог 2014 онд байгуулан 2017, 2019 онуудад тус тус өөрчлөлт оруулсан байна. 2019 онд оруулсан өөрчлөлтөөр хөтөлбөрийн бүрэлдэхүүнд хөтөлбөрт оролцогчдын төлөөллийг оруулах, төгсөгчдөөс бүрдсэн хөтөлбөрийн зөвлөх багийг байгуулан хамтран ажиллахаар шинэчлэл хийв. Зохих нийцлийг хангасан байхаас гадна, хөтөлбөрт оролцогчдийн төлөөллийг түлхүү тусгасан давуу талтай байна.
- Шихихутуг Их сургуулийн хөтөлбөр хөгжүүлэх стратеги төлөвлөгөөнд хөтөлбөрийг бүх талаар бүрэн тасралтгүй хөгжүүлэх зорилгоор хөтөлбөр хөгжлийн тусгай санг байгуулан ажиллахаар тусгасан байна.
- Хөтөлбөрийн хорооны журамд заасны дагуу ерөнхий хороо, тэнхим, мэргэжлийн зөвлөлийн /хөтөлбөрийн зөвлөх баг/ үйл ажиллагааны чиглэл, шийдвэр гаргалтын ажиллагааг уялдуулсан.
- Шихихутуг их сургуулийн сургалт, судалгааны үйл ажиллагааны эрх зүйн орчин нь Монгол Улсын Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, БСШУСЯ, ХЗДХЯ-наас батлан гаргасан дээд сургуулийн үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журам, тушаал, заавар, стандартыг мөрдөн ажиллаж байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх анхан шатны нэгж /тэнхим/ нь богино, дунд, урт хугацаагаар төлөвлөлт хийж ахиц, дэвшлийн механизмаа бүрдүүлсэн байна.
- Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой

хуваарилж, хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлэх зорилготой ажиллаж байна.

- Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Клиник сургалтын төвөөр дамжуулан оюутан дадлагажих мөн иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйг зөвөлгөөг өгөх үйл ажиллагаа жигдэрсэн.

Анхаарах асуудал:

-

Зөвлөмж:

- Хөтөлбөр хөгжүүлэх бодлого, төлөвлөлтөд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 Хуульчийн мэргэжлийн шалгалтын зорилго нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх авахыг хүссэн этгээдийн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, шүүн таслах ажиллагаанд оролцох, хууль зүйн туслалцаа үзүүлэх хангалттай мэдлэг чадвар эзэмшсэн эсэхийг тогтооход чиглэгдэнэ. 9 дүгээр зүйлийн 9.1 ..магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуулийг төгссөн иргэн хуульчийн шалгалтад орох эрхтэй гэсэн хуулийн зохицуулалттай уялдуулах.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Англи хэлний олон улсын EAP / english academic purposes/ оксфорд сургуулийн хөтөлбөрийг олон улсын “ UPTON INTERNATIONAL NNSTITUTE OF EDUCATION” ХХК-тай хамтран хэрэгжүүлэх гэрээ/ 2018.11.10/
- Сургалтын түшиц газартай үйлдвэрлэлийн дадлага хийх хуулийн салбарын байгууллагатай хамтран ажиллах гэрээ.
- Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ
Өмгөөллийн “Легал Про” ХХН / 2017.05.01 №17/11
Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газар Хамтран ажиллах санамж бичиг /2017.10.16/
Хүний эрхийн Үндэсний Комисс судалгааны ажил гүйцэтгэх гэрээ 2018.09.27 №ХЭҮК/2018/030
Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг Хуулийн төсөл, түүнд шаардагдах бусад баримт бичиг хуулийн хэрэгцээ шаардлагын урьдчилсан тандалтын судалгааны танилцуулга, хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийн тухай танилцуулга Цэцрлэгт хүрээлэнгийн тухай.
- Хөтөлбөрийн оролцогчдын тэтгэлэг, урамшуулалд хамрагдсан.

- Хуульчийн үргэлжилсэн сургалт, хуульчийн сонгон шалгаруулалтад бэлтгэх сургалт зохион байгуулсан Монголын Хуульчдын Холбоо Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо Сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлэх тухай 2015.04.30 № 3/361.
- Солонгосын Хангдун Их сургууль, ОХУ-ын Уралын их сургуулийн хуулийн сургуультай хамтран ажиллах санамж бичиг
- Сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улсын эрх зүйн орчинд тулгамдсан асуудлаар тухайн салбарын хуулийн байгууллагатай хамтран олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан баримтууд
- Клиник сургалтын төвөөр дамжуулан хууль зүйн үнэ төлбөргүй зөвөлгөөг иргэдэд тогтмол үзүүлдэг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчид болон дүүргийн иргэдэд хууль сурталчилах лекцыг тогтмол зохион байгуулдаг.
- Солонгос, ОХУ, Америкийн хуулийн сургуулиуд болон Хууль сахиулах байгууллагуудтай хамтран Монголын эрх зүйн орчны тулгамдсан асуудлаар тогтмол олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан байна.
- Клиникийн сургалтын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд, Сургалтын нэгдсэн төлөвлөгөөн дэх онол-практикийн зохистой харьцааг хангах шаардлагын үүднээс Клиник сургалтын зохион байгуулалтыг Клиникийн сонгодог сургалтын хэлбэр, Сургалтын хөтөлбөрт хослох хэлбэрээр явуулж байна.
- Судалгааны төсөл хэрэгжүүлэх хэлбэрээр хамтын ажиллагаа өргөжиж байна.
- Хөтөлбөрийн оролцогчид-төгсөгчдийн эрэлтийн нэг хэсэг нь төгссөний дараах үргэлжилсэн сургалтын тогтолцоо, давтан сургалтын шаардлага юм. Энэ хүрээнд, - Хуульчийн үргэлжилсэн сургалтын кредит олгох журмаар, -Хуульчийн мэргэжлийн шалгалтанд зориулсан сургалт хэлбэрээр зохион байгуулагдаж байна
- Хөтөлбөрт оролцогчдыг идэвхжүүлэх, хөтөлбөрийг сайжруулах санал санаачлагыг өрнүүлэх, хандлагыг төлөвшүүлэх зорилгоор тодорхой зорилтот төсөл, хөтөлбөр, хэлэлцүүлэг, хурал, семинарт оролцуулах байдал тогтмолжсон байна.
- Иргэдийн нас, эрүүл мэндийн онцлогт тохируулан хуулийн мэдлэгийг энгийн байдлаар тайлбарлан таниулах зурагт ном анимэйшн бүтээх **“БАГАЧУУДАД ЗОРИУЛСАН ҮНДСЭН ХУУЛЬ” -“ШИХИ ХҮҮ”** цуврал анимейшныг бүтээсэн.
- Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилготой **“ХУУЛЬ БА АМЬДРАЛ”** цуврал нэвтрүүлэг нь олон нийтэд өндөр үнэлэгдсэн.

Анхаарах асуудал:

•

Зөвлөмж:

•

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрт оролцогчдын хөтөлбөр хөгжүүлэх тодорхой зорилтод сургалт, төсөлд хамруулсан.
- Багш П.Түвшинтөгс, Б.Ганпүрэв, Ё.Болормаа, Ц.Амарсанаа, О.Батсүх, Ч.Жадамба, М.Хатанзориг нарт докторантурын сургалтын төлбөрийн 50 хувь тэтгэлэг, урамшуулал хэлбэрээр олгосон байна.
- Филипин улсад 1-3 сарын Англи хэлний сургалтад багш Л.Нарангэрэл, П. Баянбаатар нар хамрагдсан байна.
- Сүүлийн 5 жилд 23 оюутан тэтгэлэгт хамрагдсан байна.
- Гадаад болон олон улсын байгууллага Дэлхийн зөн 2,700,000.
- Оюу толгой ХХК 2,800,000.Тайван Улс 500 доллар
- Эрх зүйн дагнасан хөтөлбөр хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор зардлыг бүрэн шингээлтийн аргаар хуваарилсан байна. /Нэг оюутанд ноогдох зардлыг тооцохдоо нийт зардлыг нийт оюутны тоотой харьцуулан тооцсон байна./

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр хөгжүүлэх тусгай санг байгуулах талаар хөтөлбөр хөгжүүлэх стратеги төлөвлөгөөндөө тусгайлан заасан.
- Багшийн хөгжлийн хөтөлбөрөөр үндсэн таван чиглэлээр санхүүжүүлэх ажлуудыг шууд зааж өгсөн.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн зорилго, зорилтыг бүрэн дүүрэн хангахуйцаар орчны стандартын санхүүжилтийг тогтвортой, найдвартай эх үүсвэртэй байлгахын тулд оюутны төлбөрөөс гадна санхүүгийн бусад эх үүсвэрийг хуулийн хүрээнд бий болгох, санхүүгийн менежментийн бодлого боловсруулах шаардлагатай байна.

Зөвлөмж:

-

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөр хөгжүүлэх стратеги төлөвлөгөө
- Шихихутуг их сургуулийн эрдэмтдийн бүтээл нь сургууль сурталчилах нэг хэлбэр юм. Хөтөлбөрийн сурталчилгааны хүрээнд “Мэргэжлээ хэрхэн зөв сонгох вэ”, “Зорилготой залуу хүн”, “Мэргэжлээ сонгох зөвлөгөө” “Хуульч мэргэжлийн онцлог”, “Бид мөрөөдөлдөө хайртай” сэдвээр зорилтот лекцүүд
- Монголын хуульчдын холбооноос хууль зүйн их, дээд сургуулиудын дунд зохион байгуулдаг Иргэн, Эрүү, Захиргааны хэргийн шүүхийн мэтгэлцээний тэмцээнд тухай бүр амжилттай оролцож, тэргүүн, дэд, гутгаар байруудад шалгарч байв. Энэ нь чанартай боловсрол олгож байгаа сурталчилгаа гэж тайлбарлав.
- UBS global телевиз, Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэг, “Өдрийн сонин”, Зууны мэдээ”, TV-9, ТҮ-5, Сүлд, Өлзий TV, VTV, “Эко суваг ТВ-Сурталчилгаа”, Монголын бизнес, зар сурталчилгааны үндэсний агентлаг, ”ТВ-ехро тэтгэлэг” хөтөлбөр, Bolovсроl.com сайт зэрэг телевиз, хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллаж, сургуулиа сурталчилсаны зэрэгцээ оюутан элсүүлэх хөтөлбөр, элсэлтийн журмаас тухай бүр танилцуулж байсан баримт.
- МИДСК-ын шугамаар “Хөдөө орон нутгаас оюутан элсүүлэх үйл ажиллагаа”-нд жил бүр идэвхтэй оролцож хөтөлбөр, мэргэжлээ сурталчилдаг бөгөөд тус сургуулийн багш нараас зарим аймгуудад комиссын дарга, нарийн бичгийн дарга, гишүүнээр ажиллаж өөрийн сургууль төдийгүй бусад их дээд сургуулиудын хөтөлбөрийг сурталчилж, оюутан элсүүлэх ажлыг зохион байгуулсан баримт
- Нийслэлийн зарим ЕБС-иудын ахлах ангийн сурагчдад “Мэргэжлээ хэрхэн зөв сонгох вэ? сэдэвт илтгэл, “Хувь хүний хөгжлийн сургалт”, “Би оюутан болно” сэдэвт ЕБС-ийн сурагчдын дунд парламентын мэтгэлцээний аварга шалгаруулах тэмцээн, Парламентын мэтгэлцээнээр анхлан мэтгэлцэгчдийн чансаа тогтоох 9, 10 дахь удаагийн тэмцээнүүдийг тус тус амжилттай зохион байгуулсан баримтууд
- “Мишээл экспо-боловсролын үзэсгэлэн яармаг”, “Монголын оюутны холбоо”, мөн бусад газраас хамтран зохион байгуулсан “Боловсролын шинэчлэл-2016”, “Нээлттэй өдөрлөг-2014”, “Боловсролын шинэчлэл-2014”, “Боловсролын шинэчлэл-2015”, “Боловсрол шинэчлэл-2017”, “Боловсролын экспо-2015”, “Монголын боловсрол-2015”, “Монголын боловсрол-2016” зэрэг үйл ажиллагаанд эрх зүй болон бизнесийн эрх зүй хөтөлбөр сурталчилсан байна

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн стандартын шинэчлэлтэй холбоотойгоор хөдөлмөрийн зах зээлийн тандалтын хэлбэрүүдийг дараах байдлаар хийсэн байна.
- Хөтөлбөрийн үндэслэл болсон PESTLE шинжилгээ, SOCIAL үзүүлэлтүүд,
- Холбогдох яам болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, Үндэсний статистикийн хорооны “Хөдөлмөрийн зах зээлийн төлөвийн судалгаа”,
- Ажиллах хүчний судалгааны хүрээнд хийгдсэн “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”, “Залуучуудын ажилгүйдэл, эдийн засгийн идэвхгүй байдлын судалгаа”,

Хөдөлмөрийн зах зээлийн дунд болон урт хугацааны нийлүүлэлтийн таамаглал судалгаа, Элсэгч, төгсөгч, төгсөгчдийн ажил эрхлэлтийн тархалтын тандан судалгааг сүүлийн 10 жилээр, Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, төгсөгчдийн ажил эрхлэлтийн нутаг дэвсгэрийн тандалт судалгаа /map/, Тодорхой хугацааны элсэлт, төгсөлт, ажил эрхлэлтийн цикл судалгаа зэргээр шинжилгээний хүрээг өргөжүүлэв.

- Шихихутуг их сургууль нь тухайн үед тулгамдаж буй нийгэм, эдийн засаг, эрх зүйн тодорхой сэдвүүдээр 2008 оноос хойш ОУЭШБХ-ыг зохион байгуулан, илтгэлүүдийг эмхэтгэл болгон хэвлүүлж олны хүртээл болгож байгаа нь сургууль сурталчилах гол үзүүлэлт болсоор байна.

Анхаарах асуудал:

-

Зөвлөмж:

-

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- CLOUD UNIVERSITY хоорондоо уялдаа холбоо бүхий 1000 орчим дэд модультай дээд боловсролын мэдээллийн системийн цогц шийдлийг хэрэгжүүлсэн баримтууд
- Өөрийн дараах үйл ажиллагааны талаар мэдээллийг эрэмбэлэн хүргэж байна.
 1. Сургуулийн алсынхараа, Эрхэм зорилго, хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцахуйн үр дүн
 2. “Багшийн ном”, “Оюутны ном” –оор дамжуулан хөтөлбөрийн эрх зүйн баримт бичгүүд
 3. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын мэдээлэл
 4. Хөтөлбөрийг идэвхжүүлэх зорилтот уулзалт, сурталчилгаа, мэдээлэл
 5. Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны тайлан /жил бүрээр/
- Сургуулийн дотоод сүлжээ, ВЭБ сайтуудад сургуулийн бүтэц, үйл ажиллагаа, эрхэм зорилго, зорилтууд тэдгээрийн хэрэгжилтийн явц байдлыг байршуулан, мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргэдэг. [/www.shihihutug.edu.mn/](http://www.shihihutug.edu.mn/)

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн вэбсайт дахь мэдээлэл, мэдээллийн танилцуулга, тогтмолжсон.
- Оюутан <https://swidp.xcloud.mn> сайтаар орж өөрсдийн тодорхойлолт, дүн болон судлаж буй хичээлийн мэдээллээ хэвлэн авах боломжтой.

- Мэдээ үзсэн тоо 10 мэдээлэл тутамд дунджаар 1350-н хандалттай байгаа нь цахим мэдээллийг түгээх ажил жигдэрсэн.

Анхаарах асуудал:

-

Зөвлөмж:

-

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Жил бүр элсэлтийн журмыг баталж мөрдсөн ба Улаанбаатар хот болон орон нутгаас элсэгчдэд тавих шаардлагыг ялгавартай тогтоож иржээ. Тухайлбал, 2014 онд Улаанбаатар хотоос элсэгчээс зөвхөн нийгмийн тухай мэдлэгийн ерөнхий шалгалтын оноо, орон нутгаас элсэгчээс нийгмийн тухай мэдлэг 70 хувь, математик 30 хувь байхаар тогтоож байсан. Өөрийн үнэлгээний тайланд жил бүрийн элсэгчдийн ЭЕШ оноог харьцуулж шинжилгээ хийсэн байна. 2018-2019 оны хичээлийн жилээс CDIO хэрэгжүүлж байгаатай холбогдуулан элсэлтийн бодлогод өөрчлөлт орсон. Тухайлбал, элсэлтийн журмаар тогтоосон нийтлэг шаардлагаас гадна гадаад хэлний академик түвшний сургалт явуулахад шаардлагатай суурь түвшинд хүрсэн байх шаардлагыг нэмсэн байна. 2019-2020 оны хичээлийн элсэлтийн журмыг одоогоор баталж нийтэд зарлаагүй байна.
- Өөрийн үнэлгээний тайланд оюутны гарын авлагын талаар дурдаагүй, нотлох баримт хавсаргаагүй байсан тул сургууль дээр ажиллах үед авч судалсан ба оюутны төлөөлөлтэй уулзах үед гарын авлагаар хангагддаг эсэх талаар асууж хариулт авсан. Оюутны төлөөлөлтэй хийх уулзалтын үед зарим оюутан оюутны гарын авлагыг өөртөө авч явснаа үзүүлсэн болно.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тайланд 2014-2017, 2018-2019 оны хичээлийн жилд элсэгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтын оноог харьцуулан авч үзсэн нь онцлог сайн туршлага гэж үзэж болох боловч элсэгчийн чанарт дүн шинжилгээг хийгээгүй.

Анхаарах асуудал:

- Элсэлтийн бодлогод өөрчлөлт орсон талаар "нэмэгдүүлэх байдлаар ажиллаж байна" гэснийг илүү тодорхой болгож бодлогоо тодорхойлсон баримт бичгийн эх сурвалжийг зааж өгөх.
- Оюутны гарын авлагыг нотлох баримт болгох.
- Гадаад оюутны талаарх мэдээлэлийг тайланд тусгах шаардлагатай.

Зөвлөмж:

- Өөрийн үнэлгээний тайлангаас үзэхэд орон нутгаас элсэгч авах сонирхолгүй гэж ойлгогдож байгаа тул энэ талаар тайланд тусгах нь зүйтэй.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

Шинээр элсэгч нарт их сургуулийн бүтэц, зохион байгуулалт, дүрэм журам, багц цагийн журам, амжилттай сурах үндэсийн талаар хичээлийн жилийн эхэнд танилцуулж хэвшсэн. Мөн сургуулийн хэмжээний болон улсын чанартай уралдаан тэмцээнд амжилттай оролцох, сурлагаар тэргүүлсэн оюутанд сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх журмын талаар танилцуулдаг байна. Чиглүүлэх сургалтын төлөвлөгөө буюу оюутанд зөвлөн туслах багш нарын хувиарыг баталж мөрддөг.

Энэ төлөвлөгөөний гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл тайланд тусгагдаагүй байсан тул сургууль дээр ажиллах үед авч судалсан болно.

Хичээлийн жилийн туршид сэтгэл ханамжийн судалгааг авч тэнхим, сургуулийн улирал тутмын хурлаар хэлэлцэн дүгнэдэг байна.

Их сургуулийн хэмжээнд Гэрэгэ, Радикс, Их заргач клубүүд үйл ажиллагаа явуулдаг. Их сургуулийн захирлын "Оюутны хөгжлийн төв байгуулах тухай" 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/46 дугаар тушаалаар Оюутны хөгжлийн төвийг зохицуулагч багш нэг, клубын зөвлөх багш 3, нийт 4 орон тоотойгоор байгуулан ажиллаж байна. Оюутны хөгжлийн төвийн үйл ажиллагаанд анги удирдсан багш, зөвлөх багш, сургалтын менежер нар оролцдог байна. Мөн тушаалаар оюутны хөгжлийн төвийн дүрмийг баталж мөрдүүлжээ.

Их сургуулийн захирлын 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/104 дүгээр тушаалаар Шихихутаг их сургуулийн оюутны хөгжлийн хөтөлбөрийг баталж хэрэгжүүлж байна.

Удирдах зөвлөлөөс Оюутны сайн дурын клубын үйл ажиллагааны төсвийг 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн жил бүр баталж зарцуулж ирсэн. Гэвч баталсан төсвийн 10-25 орчим хувийг л зарцуулж ирсэн байна. Төсөвлөсөн хөрөнгийн зарцуулалт хангалтгүй байгааг анхаарч бодитой төсөвлөх, оюутны хөгжлийг дэмжсэн бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах нь зүйтэй байна.

2014-2018 онд нийт 23 оюутын гадаад, дотоодын тэтгэлэгт хамрагдсан нь таван жилийн дунджаар нийт оюутны 0,8 хувийг эзэлж байна. Их сургуулийн хэмжээнд 2014, 2015 онд тус бүр 4, 2016 онд 11, 2017 онд 8, 2018 онд 4 оюутанд 10-50 хувийн сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

•

Анхаарах асуудал:

- Оюутанд зөвлөн туслах үйлчилгээний талаар нэгдсэн бүртгэл, тайлан тооцоо хөтөлдөггүй.

Зөвлөмж:

-

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны сайн дурын ажлыг дэмжих эрх зүйн орчинг бүрдүүлж их сургуулийн захирлын 2018 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр Оюутны сайн дурын ажлыг үнэлэх журмыг баталж 2018-2019 оны хичээлийн жилээс мөрдөж байна. Оюутны сайн дурын ажил гүйцэтгэсэн талаарх мэдээллийг төгсөлтийн баримт бичигт тусгахаар бэлтгэж байгаа талаар танилцуулсан болно.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны сайн дурын ажлыг дэмжих журам гарган мөрдөж эхэлсэн.

Анхаарах асуудал:

- Энэ хичээлийн жилээс эхэлж мөрдөж байгаа журам байгаа тул сайн дурын ажлыг бүртгэдэг үр дүнг тооцдог механизмыг бий болгож хэвшүүлэхэд анхаарах нь зүйтэй.

Зөвлөмж:

-

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний талаарх мэдээлэл өөрийн үнэлгээний тайланд хангалтгүй тусгагдсан. Сургууль дээр ажиллах үед их сургуулийн захирлын 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/20 дугаар тушаалаар баталсан “Бакалаврын сургалтын журам”-тай танилцсан ба тухайн журмын 8 дугаар бүлэг багц цагийг дүйцүүлэх тооцох журмыг тогтоосон байв.

Өөрийн үнэлгээний тайлангийн 79 дүгээр хуудсанд оюутны шилжилт хөдөлгөөнийг хэрхэн шийдвэрлэдэг, сүүлийн таван жилд хэдэн асуудал хэрхэн шийдвэрлэсэн, багц цагийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцсон, багц цагаас чөлөөлөх зэрэг талаар мэдээлэл тусгаагүй боловч нэмэлт мэдээллээр Шихихутуг их сургуулийн захирлын 2016 оны 10-р сарын 12-ны өдрийн А/57 тоот тушаалын хавсралт “Оюутны шилжилт хөдөлгөөний журам”-ын дагуу оюутны шилжилт

хөдөлгөөн, багц цагийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох зэрэг асуудлыг шийдвэрлэсэн талаар мэдээллийг хамвралтаас үзэх боломжтой.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Онцлог буюу сайн туршлага гэж үзэх зүйл тайланд тусгагдаагүй болно.

Анхаарах асуудал:

Зөвлөмж:

-

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Шихихутуг их сургуулийн захирлын 2019 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/28 дугаар тушаалаар Төгсөлтийн баримт бичгийг загварыг баталж мөрдөн ажиллаж байна. Өөрийн үнэлгээний тайланд төгсөлтийн баримт бичигт тавигдах шалгуур, нийцлийн матриц хийж харуулсан бөгөөд тайлангийн хавсралтаар жил бүрт олгосон дипломын хуулбараас загвар болгон хавсаргасан. Эдгээрээс үзэхэд Шихихутаг их сургуулиас олгодог төгсөлтийн баримт бичиг буюу бакалаврын диплом нь Боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Улсын их хурлын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2014-2024 он” баримт бичигт нийцэж байна гэж үзлээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөлтийн баримт бичиг буюу диплом, түүний хавсралтаар оюутны гүйцэтгэсэн сайн дурын ажлыг баталгаажуулахаар сургалтын хөтөлбөрт тусгасан.

Анхаарах асуудал:

Зөвлөмж:

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

Шихихутаг их сургуулийн багшлах хүний нөөцийн бодлого нь сургуулийн эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийн хувьд мэргэшсэн, чадварлаг багш, ажилтны зохистой харьцааг бүрдүүлж тэдний тогтвортой ажиллах нөхцлийг хангасан эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэдэг. Өөрийн үнэлгээний тайланд багшид тавигдах шаардлагыг тусгаж үндэсний болон сургуулиас багшид тавигдах шаардлагад нийцэж байгаа эсэхэд матриц шинжилгээ хийж шаардлага хангасан гэж дүгнэжээ.

Нийт багш нарын 84 хувь нь үндсэн багш байх, 30 хувь нь докторын зэрэгтэй байх, багш бүр ажлын байрны тодорхойлолтой байх, багш нарын 70 хувиас доошгүй нь эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэдэг байх багшийн гүйцэтгэх ажлын ногдол, түүний үнэлгээний зааварын дагуу ажлын ачааллыг тооцох, үнэлэх ажлыг зохион байгуулдаг байх шаардлагыг хангасан байна.

Харин нэг багшид ногдох оюутны тоо сүүлийн 5 жилд дунджаар 38 байгаа нь нэг багшид оногдох оюутны тоо 25 байх шаардлагыг хангахгүй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

-

Анхаарах асуудал:

- Нэг багшид ногдох оюутны тоонд тавигдах шаардлагыг хангах талаар тодорхой ажил зохион байгуулах, үр дүнг тооцох шаардлагатай.

Зөвлөмж:

-

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Их сургуулийн захирлын 2016 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн а/51 дүгээр тушаалаар Багшийн хөгжлийн хөтөлбөрийг 2016-2020 хэрэгжүүлэхээр баталж мөрдсөн. 2018-2019 онд уг хөтөлбөрийн дунд хугацааны биелэлтэд дүн шинжилгээ хийж үнэлгээ хийсэн.
- Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгаа хийж дүгнэлт хийжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

-

Анхаарах асуудал:

- Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх.

Зөвлөмж:

•

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын судалгаа хийж баримтыг хавсаргасан. Тайлангийн хугацаанд эрх зүйн боловсролыг сурталчлах нийгмийн хариуцлагын хүрээнд Багачуудад зориулсан үндсэн хуулийн танилцуулга, Багачуудад зориулсан үндсэн хууль бүтээлд зохиогчийн эрхийг баталгаажуулсан байна.
- Эрдэм шинжилгээний ажилд зориулсан төсөв жил тутам өссөн дүнтэй. (2018-2019 оны хичээлийн жилийнх тайланд тусгагдаагүй)
- Их сургуулийн захирлын 2017 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн тушаалаар Их сургуулийн хөгжлийн ерөнхий зураглалыг баталж мөрдөн ажиллаж байгаа бөгөөд 3 дугаар зорилтыг Сургалт, судалгааны арга технологийг хөгжүүлэх, эрдэм шинжилгээний ажлын чанарын сайжруулах, инновацийг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ, багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг үнэлж дүгнэх, урамшуулах журмыг шинэчлэнэ гэж заасан.
- Их сургуулийн стратеги төлөвлөгөөний хоёрдугаар зорилтоор эрдэм шинжилгээний ажлын чанарыг сайжруулах, инновацийг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ гэж заажээ.
- Их сургуулийн захирлын 2016 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/71 дүгээр тушаалаар Багш ажилтанд шинжлэх ухааны доктор, боловсролын доктор хамгаалсан бол мөнгөн урамшуулах олгох тухай журмыг, 2016 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/57 дугаар тушаалаар Багшийн ур чадварыг үнэлэх, цалингийн нэмэгдэл, бусад шагнал урамшуулал олгох журмыг баталж эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьсан, эрдэм шинжилгээний ажил тууштай эрхэлж байгаа тохиолдолд мөнгөн урамшуулал олгож байхаар журам тус тус баталж мөрдсөн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багачуудад зориулсан үндсэн хуулийн танилцуулга, Багачуудад зориулсан үндсэн хууль бүтээлд зохиогчийн эрхийг баталгаажуулсан байна.

Анхаарах асуудал:

- Их сургуулийн хөгжлийн зураглал, стратеги төлөвлөгөөнд тусгасан багшийн хөгжил, эрдэм шинжилгээний ажлыг дэмжих талаар ажлын гүйцэтгэлийг хангах.

Зөвлөмж:

-

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн өөрийн үнэлгээний тайланг сургалт, сурган заах арга зүй, эрдэм шинжилгээний ажил, олон нийтийн зохион байгуулалтын ажил гэсэн гурван чиглэлээр бичиж нотлох баримтуудыг бүрдүүлэн ажилладаг. Багш нэг бүр өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөг бичиж биелэлтийг дүгнэдэг.
- Багшийн хэрэгцээний судалгааг хийж түүний дүнд үндэслэн Багшийн хөгжлийн төвийг байгуулан ажиллаж байна.
- Багш нэг бүрийн хавтастай танилцахад багшийн өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгшөө, А цагийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, заадаг хичээлийн хөтөлбөрүүд, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ зэргээс бүрдэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

-

Анхаарах асуудал:

- Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх дүгнэх журам байхгүй.
- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний тайлан мэдээ тусгагдаагүй.

Зөвлөмж:

- Багшийн өөрийн үнэлгээний тайланг хэлэлцэх, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үр нөлөөг тооцох механизм бүрдүүлэх ажиллах.

6-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Дотоод чанарын баталгаажуулалтын нэгж байгуулж тушаал, шийдвэрээр баталгаажуулсан
- Энэ нэгжийн ажиллах дүрэм, журам, удирдамжийг боловсруулан баталгаажуулсан.

- Оролцогч талуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах замаар чанарын баталгаажуулалт хийх ажлыг эхлүүлж холбогдох нотолгоог бүрдүүлсэн.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Одоогоор онцолж, түгээх дэлгэрүүлэх туршлага байхгүй гэж үзэж байна.

Анхаарах асуудал:

- Чанарын баталгаажуулалтыг хөтөлбөрийн бүх бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд хэрхэн зохион байгуулах, ямар схем, арга зүйн дагуу хэрэгжүүлэх, үр дүнг хэрхэн үнэлэх, тасралтгүй сайжруулалтын циклийг хэрхэн ажиллуулах механизмыг бүрэн хэрэгжүүлж чадаагүй гэж үзэж байна.

Зөвлөмж:

- Сургалтын хөтөлбөрийн бүх бүрэлдэхүүн хэсгүүдийг үр дүнд суурилсан боловсролын арга зүйн дагуу үнэлэх иж бүрэн загварыг бий болгох, хэрэгжүүлэх талд анхаарч ажиллах
- Сургалтын чанарт өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх механизмыг бүрдүүлж, хэрэгжүүлж хэвших

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг 1996-2016 оны төгсөгчдийг хамруулан хийж, холбогдох дүн шинжилгээнд үндэслэн тайлан гаргасан байна.
- Хуульчийн мэргэжлийн шалгалтын үр дүнгээр төгсөгчдийн чадамжийн түвшинг тогтоох судалгааг хийж хавсаргасан.
- Төгсөх оюутнуудаас хөтөлбөрийн үр дүнгийн талаар судалгаа авч дүн шинжилгээ хийсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ажил олгогчид, төгсөгчид, багш нарын төлөөлөлтэй уулзах үед тус сургуулийн төгсөгчид сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг бүрэн хангаж байгаа нь харагдаж байлаа. Ялангуяа хувь хүний хөгжил, ёс зүй, харьцаа, бие хүний төлөвшил талд энэ сургуулийн төгсөгчид бусад сургуулиас ялгарч байгаа нь энэ чиглэлд сургууль хэр сайн ажиллаж байгааг баталж байна гэж үзэж байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн хүрсэн түвшин ямар байгаа, цаашид энэ чиглэлийн ажлын байранд ямар мэдлэг, ур чадвар бүхий төгсөгч хэрэгцээтэйг тодорхойлоход оролцогч талуудыг саналыг тусгах ажил хангалтгүй байлаа.

Зөвлөмж:

- Эрх зүйн хөтөлбөрөөр төгсөгчдийн ажлын байрны судалгаа, карьер өсөлтийн судалгаа, тэдэнд зайлшгүй шаардлагатай мэдлэг, ур чадварын судалгааг гаргах
- Оролцогч талуудыг иж бүрэн судалгаагаар хөтөлбөрийн боловсролын зорилтууд, суралцахуйн үр дүнгүүдийн ач холбогдол болон гүйцэтгэлийн түвшинг тодорхойлж, тасралтгүй сайжруулах тогтолцоог бүрдүүлэх

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Байгууллагын магадлан итгэмжлэлийн хүрээнд шинжээчдээс өгсөн санал, зөвлөмжийн дагуу зохион байгуулсан ажлын үр дүн болон төлөвлөлтийг тайланд дэлгэрэнгүй тусгасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Англи хэлний Оксфордын стандарт сургалтыг оруулж ирж, 12 кредитийн хичээл судлан олон улсын түвшний сертификатын шалгалт өгөх боломж бүрдүүлсэн нь хэлний талаас олон улсад хүлээн зөвшөөрүүлэх ажлын эхлэл болсон гэж үзэж байна.

Анхаарах асуудал:

- Хэдийгээр төгсөгчдийн чанараар МУИС-ийн дараа орж байгаа гэсэн мэдээллийг төгсөгчид, ажил олгогчид өгч байгаа ч энэ талаар судалгаа хийж нотлох баримт бүрдүүлэх талд тааруу ажиллажээ.

Зөвлөмж:

- Эрх зүйн хөтөлбөрт тавьдаг олон улсын стандарт шаардлагын дагуу хөтөлбөрт иж бүрэн үнэлгээ хийх
- Хуульчийн мэргэжлийн шалгалтын агуулгыг хөтөлбөрийн агуулгатай холбох асуудлыг судалж, хэрэгжүүлэх
- Бакалавр, магистрын сургалтын залгамж холбоог сайжруулах

7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Шихихутуг их сургуулийн “Эрх зүй” хөтөлбөрт шинжээчдийн зүгээс дараах нэгдсэн үнэлгээг өгч байна.

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2	Сургалтын үйл ажиллагаа	2			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
6	Багшийн үйл ажиллагаа	2			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Шихихутуг их сургуулийн “Эрх зүй” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ бүрэн хангасан” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрх зүйн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/А.Оюунчимэг/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Д.Эрдэнэбаатар/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Н.Эрдэнэхүү/

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

- Цаашид хөтөлбөрийн зорилго зорилтууд, суралцахуйн үр дүнгүүдийг мэргэжилтний загвартай уялдуулж тасралтгүй сайжруулах
- Хичээлээр олгох мэдлэг, ур чадвар, хандлагуудыг нарийн томьёолох, сургалтанд ашиглахаар төлөвлөсөн шинэ аргуудыг хэрэгжүүлэх, сургалтын явцын болон эцсийн үнэлгээг хичээлийн суралцахуйн үр дүнтэй холбож хийх ажлыг хэвшил болгох
- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг тасралтгүй хийх арга зүй, удирдамж боловсруулах, энэ талаар профессор багш нарт сургалт явуулах, хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох
- Үр дүнд суурилсан боловсролын тогтолцоог эрх зүйн хөтөлбөрт нэвтрүүлэх чиглэлээр хийсэн ажлын үр дүнг түгээн дэлгэрүүлэх талд анхаарч ажиллах, өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах.

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Овог нэр	Мэргэ-жил	Цол зэрэг	Албан тушаал	Заадаг хичээл	Багшилсан жил
1	Роломсүрэн Оюунбадам	Хуульч	Доктор / Ph.D/	Клиник сургалтын төвийн эрхлэгч	Шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүй	12
2	Нанзаддорж Жалбажав	Философич	Доктор /Ph.D/ профессор	“Шихихутуг” хүрээлэнгийн захирал	Эрх зүйн философи	5
3	Дагдан Отгонтуяа	Хуульч	Магистр, ахлах багш	Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн эрхлэгч	Төрийн онол, Эрх зүйн философи	21
4	Хүүхлээ Одонтуяа	Хуульч	Магистр	Багш	ҮХ-ийн эрх зүй, Санхүү, банкны эрх зүй, Татварын эрх зүй	9
5	Бавуудорж Ганпүрэв	Эрх зүйч	Магистр	Ахлах багш	Эрх зүйн онол	13
6	Пүрэвжав Баянбаатар	Хуульч	Магистр	Эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч	Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн процесс	11
7	Ёндон Болормаа	Хуульч	Магистр	Ахлах багш	Хөдөлмөрийн эрх зүй, НХЭЗ	10
8	Цэнджав Амарсанаа	Эрх зүйч	Магистр	Багш	Захиргааны эрх зүй, Захиргааны процесс	8
9	Очирбат Батсүх	Эрх зүйч	Магистр	Багш	Эрүүгийн эрх зүй	4
10	Эрдэнэбаатар Анхбаяр	Эрх зүйч	Магистр	Багш	Захиргааны эрх зүй	4
11	Мөнхбаяр Хатанзориг	Эрх зүйч	Магистр	Багш	Иргэний эрх зүй	4
12	Алтангэрэл Доржготов	Хуульч	Магистр	Иргэн, бизнесийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч	Иргэний хууль тогтоомжийн хэрэглээ	5
13	Лхагвасүрэн Нарангэрэл	Гадаад хэлний багш	Доктор /Ph.D/ Ахлах багш	Ерөнхий эрдмийн тэнхимийн эрхлэгч	Англи хэл	15
14	Ганболд Амаржаргалан	Хуульч	Магистр	Багш	Иргэний эрх зүй	
15	Дашням Одон	Англи хэлний багш	Магистр	Багш	Англи хэл	1
16	Сосорбарам Батболд	Англи хэлний багш	Магистр	Багш	Англи хэл	1
17	Болдбаатар Хүрэлчулуун	Монгол, Англи хэлний багш	Магистр	Багш	Монгол хэл, бичиг найруулга зүй	2

18	Галданбошигт Насантогтох	Эрүүгийн эрх зүйч	Магистрант	Туслах багш	Хууль зүйн клиник сургалт	1
19	Эрдэнэжаргал Ариунаа	Хуульч	Магистр	Багш	Иргэний хууль тогтоомжийн хэрэглээ, Өмчийн эрх зүй, Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа	1

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
1	Б.Пүрэвжав	4 а	Өмнөговь
2	Г.Анужин	4а	Өмнөговь
3	Б.Амирлан	4б	Улаанбаатар
4	Э.Эрдэнэчулуун	4б	Өвөрхангай
5	А.Хулангоо	3а	Radix клуб
6	О.Дэлгэрцэцэг	3а	Улаанбаатар
7	Д.Золжаргал	3б	Гэрэгэ клуб
8	Ц.Ишинноров	3в	Улаанбаатар
9	Д.Цэнгүүн	3в	Улаанбаатар
10	Т.Мөнхтулга	2а	Гэрэгэ клуб
11	Т.Кунайым	2а	Баян Өлгий
12	Э.Номинсүрэн	2б	Өмнөговь
13	Б.Гүрбазар	2б	Улаанбаатар
14	Б.Хонгорзул	2в	Бизнесийн эрх зүй чиглэл
15	А.Тунамал-эрдэнэ	1а	Шинэ төлөвлөгөөгөөр
16	Х.Идэрбаяр	1а	Шинэ төлөвлөгөөгөөр
17	О.Энхчимэг	1б	Ангийн дарга
18	Б.Хонгорзул	1б	Дотуур байр
19	А.Луубаатар	1в	Сэлэнгэ
20	Д.Энхтогтох	1в	Шинэ төлөвлөгөөгөөр

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1.	Л.Хосбаяр	Монгол Улсын Их Хурлын тамгын газар	
2.	Э.Түвшинжаргал	Монгол Улсын Их Хурлын тамгын газар	Хуулийн хэлтсийн дарга
3.	Д.Батхишиг	Мөнхийн тул ХХК	ТУЗ-ын дарга
4.	Н. Алтангэрэл	Хүний эрхийн комисс	Ажлын албаны дарга
5.	Б.Дөлгөөн	Изинис эйрвэйс ХХК	Эрх зүйн хэлтсийн дарга
6.	Б. Одонтуяа	Татварын Ерөнхий газар	Сургалтын албаны ажилтан
7.	Д.Дорждэрэм	Степпкупер ХХК	Захиргаа, эрх зүйн хэлтсийн дарга

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	М.Энх-Амгалан	2018	Палатинум консалтинг	Өмгөөлөгчийн туслах
2	Ц.Солонго	2018	Баялаг оргилон ундрах	Захирал

3	С.Жаргалмөнх	2018	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ	Хууль, гэрээ, эрх зүйн мэргэжилтэн
4	Д.Бямбасүрэн	2018	Сод консалтинг	Өмгөөлөгчийн туслах
5	Ч.Сайхнаа	2014	Амар оюуны хөрөнгө оруулалт ХХК	Захирал
6	Б.Энхболор	2014	Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	Шүүгчийн туслах
7	Б.Урангоо	2014	Коко уул ложистик ХХК	Хуулийн зөвлөх, менежер
8	М.Билгүүтэй	2015	Бодь эрин ХХК	Хуулийн зөвлөх
9	Э.Лувсангэндэн	2015	Эрдэнэс оюу толгой ХХК	Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн
10	Х.Тулга	2015	Цаст констракшин ХХК	Эрх зүйч
11	Д.Цэнгэлсүрэн	2016	Улаанбаатар төмөр зам	Арга зүйч
12	Н.Долгор	2007	Дива продакшин	Зөвлөх
13	Ц.Мөнхцэцэг	2016	ШУТИС	Хуулийн зөвлөх
14	Б.Билгүүн	2017	Хайрхан ойл ХХК	Хуулийн зөвлөх
15	Б.Сэлэнгэ	2018	НШШГ газар	Шийдвэр гүйцэтгэгч
16	У.Буянзаяа	2017	Скайтел групп	Авлагын хуульч
17	Т.Оюун-Эрдэнэ	2017	Өмгөөллийн И эл Си ХХН	Хуулийн зөвлөх
18	Ч.Аюушцэрэн	2017	Баянгол дүүргийн шүүх	Нарийн бичгийн дарга
19	Р.Пүрэвнямсүрэн	2017	Эм жи жи и си ХХК	Хуулийн зөвлөх менежер
20	Д.Бариадилхагва	2017	Монголын хуульчдын холбоо	Судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/